*За[illegible]ийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА Р.ГАНТУЯАГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн хугацаа | Биелэлтийн хувь |
| НЭГ. АНХАН БОЛОН ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1 | ЗГҮАХ 2.1.1.3<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>МУХТ 1.3.1<br>ЭМССТ 1.8<br>“Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | | Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 5 зорилтын хүрээнд 72 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 80.1 хувьтай байна. Тодруулбал,<br>• 1-р Зорилт 69%<br>• 2-р Зорилт 89%<br>• 3-р Зорилт 81,5%<br>• 4-р Зорилт 94%<br>• 5-р Зорилт 67,1% байна.<br><br>Арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн үр нөлөөний шалгуур үзүүлэлт:<br>Улсын хэмжээнд 2024 оны 12 сарын 03-ны байдлаар 52514 эх төрж, 52830 хүүхэд амьд төрсөн байна. Амьгүй төрөлтийн түвшин 5.1 болж, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар буурсан байна. Улсын хэмжээнд 11 эх эндэж, эхийн эндэгдлийн харьцаа өмнөх оны мөн үеэс 4.4 пунктээр буурсан байна. Харин тав хүртэлх насны 809 хүүхэд эндэж, эндэгдлийн түвшин 15.3 болж, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр өссөн бол нэг хүртэлх насны 645 хүүхэд эндэж, | 09 | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эндэгдлийн түвшин 12.2 болж, өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан байна. Нярайн эндэгдэл 403 нярай эндэж, эндэгдлийн түвшин 7.6 болж, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурсан байна. | | |
| 2 | УИХ-ын 23 дугаар тогтоолын 2.2.1 ЗГҮАХ 2.1.1.5 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.15 “Элэг бүтэн Монгол” арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | | 18-аас дээш насны хүн амын 50 хувь нь элэгний өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан байна. | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөнд туссан эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой 10 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсны 6 арга хэмжээ-100%, 2 арга хэмжээ -50%%, 2 арга хэмжээ 30%, 1 арга хэмжээ 0%-ийн дундаж хэрэгжилтийн хувь 78 болгон нэмэгдүүллээ<br>Зохион байгуулсан үйл ажиллагааг тодруулбал,<br>• Эрүүл мэндийн сайдын 2023 оны 7 дугаар сарын 5-ны А/250 тоот тушаалаар булевиртид эмийг “Өнчин эмийн жагсаалт”-д бүртгэж, Монгол Улсад эмчилгээнд нэвтрүүлэх, эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.<br>• Гепатитын D вирусийн халдвартай иргэдэд урсофальк эмийг хөнгөлөлттэй үнээр олгох тоо хэмжээг 2 дахин нэмэгдүүллээ.<br>• Оношилгоо шинжилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор ХӨСҮТ-ийн лабораторид 30 гаруй нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжийг суурилуулж, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын гепатитын B, D вирусийн халдварыг илрүүлэх, ачаалал тодорхойлох шинжилгээнд зарцуулах санхүүжилтийг нэмж хуваарилсан.<br>• “Гепатитын B, D вирусийн шалтгаант архаг үрэвслийн үед D вирусийн эсрэг булевиртид эмчилгээг хийж байх хугацаанд болон гепатитын B, D вирусийн шалтгаант элэгний циррозын Чайлд-Пьюгийн ангилалд үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг нэмэгдүүлсэн шийдвэрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран гаргасан.<br>• Эмнэлгийн тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ХӨСҮТ-ийн амбулаторийн тасагт гепатитын B, D вирусийн халдвартай иргэдэд үйлчлэх хэсгийг өргөжүүлэн шинээр кабинет нээж, үйл ажиллагаа нь эхлүүлсэн. | 09 | 80% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | • Эрүүл мэндийн сайдын 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн “Журам, заавар батлах тухай” тушаалын дагуу А/18 дугаар тушаалаар “Гепатитыгн В, С, D вирусийн эмнэлзүйн заавар” баталж эрхзүйн орчинг шинэчиллээ.<br>• Эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг сайжруулах хүрээнд 21 аймаг 9 дүүргийн 400 гаруй эмч, мэргэжилтнүүдэд танхим болон цахим сургалт зохион байгуулсан.<br>• Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2024 оны 04 тогтоолыг батлуулсан. Тус тогтоолоор “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөө (2022-2025)-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, D вируст гепатитын халдвартай иргэдийн эмчилгээний зардлыг шийдвэрлэх чиглэл өгсөн.<br>• Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Монгол Улс хооронд өр хөрвүүлэх хэлэлцээр хийж, үүний үр дүнд Гепатитын вирусийн халдварын илрүүлэг, оношилгоо, эмчилгээний тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн санхүүжилтийг Глобаль Сангаар дамжуулан хэрэгжүүлэх төслийг боловсруулан Глобал Сангийн түхникийн хороонд хүргүүлсэн. | | |
| 3 | ЗГҮАХ 2.1.1.6 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.6 “Харшлаас сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх. | Оношилгоо эмчилгээний заавар 2 | | Хавьтал харшлын дерматит, Чонон хөрвөсийн эмнэл зүйн заврыг боловсруулж батлуулах | • Жинхэнэ цэврүүтэх өвчний оношилгоо, эмчилгээ MNS 5601-8-2:2006<br>• Ягаан үлд өвчний оношилгоо, эмчилгээ MNS 5601-6-1:2006<br>• Чонон хөрвөс өвчний оношилгоо, эмчилгээ MNS 6715:2018<br>• Хавьтал, харшлын дерматит өвчний оношилгоо, эмчилгээ MNS 5601-2-3:2006<br>• Бүслүүр үлд өвчний оношилгоо, эмчилгээ MNS 5601-4-1:2006 стандартуудыг орлон хэрэглэх баримт бичгийн хүрээнд эмнэлзүйн заавар болгон боловсруулж, санал авахаар тойруулж байна. | 09 | 80% |
| 4 | ЗГҮАХ 2.1.1.7 МУХТЖҮЧ 2.2.2 ЭМССТ 1.7 | Төлөвлөсөн арга хэмжээний | | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дүгээр тушаалаар “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 4 зорилтын | 09 | 100% |

180

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээ хэрэгжүүлэх. | хэрэгжилтийн хувь | | хамрагдах эрэгтэйчүүдийн хувь 70-д хүрсэн байна. | хүрээнд 43 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 75.6 хувьтай хэрэгжсэн байна.<br>• 1-р зорилт 65.8%<br>• 2-р зорилт 89%<br>• 3-р зорилт 84.8%<br>• 4-р зорилт 62.6%<br><br>2024 оны 11 дүгээр сарын байдлаар эрт илрүүлэг үзлэгт улсын хэмжээнд 1.5 сая хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүн амын 45.8 хувийг эзэлж байна. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн 43%-ыг эрэгтэйчүүд эзэлж байна. энэ нь зорилтот түвшний 62.8%-ийг хамруулсан байна. | | |
| 5 | ЗГҮАХ 2.1.2.2 Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулна. | Эмчилгээнд хамрагдсан хувь Санхүүжил-тийн хэмжээ | | Эмчилгээнд хамрагдах хувийг 50 хувьд хүргэсэн байна. Санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлсэн байна. | Элэг бүтэн Монгол” арга хэмжээний хүрээнд Монгол Улсад мөрдөгдөж буй “Гепатитын B,C,D вирусийн халдварын илрүүлэг, тандалт, оношилгоо, эмчилгээний заавар”-ыг шинэчилж ЭМС-ын 2024 оны А/18 тушаалаар баталсан. Тус зааварт гепатитын D вирусийн эсрэг эмчилгээнд ПЭГ-интерферон, Булевиртид (Bulevirtide) эмийн эмчилгээг сонголтоор хэрэглэх горим, эмчилгээний хяналтын шалгуурын тухай тодорхой тусгасан. Иргэдийг ПЭГ-интерферон, Булевиртид эмийн эмчилгээнд хамруулах үйл ажиллагааг ЭМС-ын 2024 оны 6 дугаар сарын А/272 дугаар тушаалын дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төв удирдан зохион байгуулж, “Гепатитын D вирусийн эсрэг эмчилгээнд хамруулах өвчтөн болон эмчилгээний горим сонгох, эмчилгээний үр дүнг хянах орон тооны бус мэргэжлийн эмч нарын баг”-ийг байгуулан ажиллаж байна. Тус баг нь эмчилгээнд хамрагдах эмнэлзүйн тусгай шалгуур, лабораторийн үзүүлэлтийн дагуу өвчтөнийг эмчилгээнд хамруулах, эмчилгээний хяналт хийж, үр дүнг үнэлэх ажлыг удирдамжийн дагуу хийж байгаа.<br>“Элэг бүтэн Монгол” арга хэмжээний санхүүжилтээр АНУ-ын Гилеад Сайенс компанийн үйлдвэрлэсэн Булевиртид (Hepcludex) тариаг худалдан авч **136** хүнийг, ПЭГ-интерферон эмчилгээнд **239** хүнийг гепатитын D вирусийн эсрэг эмчилгээнд хамруулсан байна. | 09 | 80% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ПЭГ-интерферон эмчилгээнд хамрагдаж буй хүмүүсийн 31 хувийг 30-39 нас, 41 хувийг 40-49 нас, 21 хувийг 50-59 насныхан эзэлж байгаагаас 11 хүн аймаг, орон нутгаас байна. Харин Булевиртид (Hepcludex) эмчилгээнд хамрагдаж буй хүмүүсийн 23 хувийг 30-39 нас, 32 хувийг 40-49 нас, 29 хувийг 50-59 насныхан эзэлж байна. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.2.2-т "Д вирустэй иргэдийг 50-ас дээш хувийг эмчилгээнд хамруулна" гэж туссан бөгөөд нийт 10.000.000.000 төгрөгөөр 10.000 /нэг хүний эмчилгээ 1.000.000 төгрөг/ хүнийг эмчилгээнд хамруулахаар төсөвлөсөн.<br>Гэвч ПЭГ-интерферон эмчилгээний нэг курс (48 долоо хоног) 1.000.000 орчим төгрөг, Булевиртид (Hepcludex) эмчилгээний нэг курс (1 жил) 66.000.000 орчим төгрөг болсон тул төлөвлөгөөний төлөвлөсөн санхүүжилтээр зорилтот түвшинд хүрэх боломжгүй болсон. | | |
| 6 | МУХТЖҮЧ 2.2.6, ЗГҮАХ-2.1.3 МУХТ 3.3.2.7. Монгол Улсад оношлогдох, эмчлэгдэх боломжгүй өвчний чиглэлээр технологи нэвтрүүлнэ. | Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчин эмгэгийн жагсаалтаас хасагдсан өвчин эмгэгийн тоо | | Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчин эмгэгийг 23 болж бууруулна. | Шинэ технологийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохоор Лавлагаа шатлалын 6 эрүүл мэндийн байгууллагын 25 төслийг ШУТЗ-өөр хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.<br>Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/273 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Уг тушаалаар Монгол Улсад эмчлэх боломжгүй онош 26-аас 25 болж буурсан.<br><br>Гадаад эмчилгээний жагсаалтад байсан өвчин эмгэгээс дараах эмчилгээний технологийг нэвтрүүлсэн:<br>1. Дутуу нярайн торлогийн эмгэгийн улмаас торлог ховхрох үеийн торлог шилэнцрийн мэс заслыг бүрэн нэвтрүүлсэн (В6).<br>2. Яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх мэс заслын 2 заалтаас мөч хадгалах боломжтой үеийн хорт хавдрын нөхөн сэргээх мэс заслыг нэвтрүүлсэн (Д14).<br>3. Сонсголын мэдрэлийн хавдрын үеийн мэс засал эмчилгээг нэвтрүүлсэн ч одоогоор бүрэн нутагшаагүй гэж үзсэн тул хэвээр үлдээсэн (Б3). | 09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. Хүзүү, нурууны нугас тасарсан гэмтлийн үеийн мэс засал (Ё18) ба сээр, бүсэлхий нурууны төрөлхийн муруйлт эмгэгийн мэс заслын эмчилгээ (Ё19)-ээс хөнгөн, дунд хэлбэрийн үеийн мэс заслыг хийж эхэлсэн. Одоогоор "хүнд" хэлбэрийн үед мэс засал хийгдэхгүй байна.<br>5. Бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг нутагшуулсан (Ж22).<br>6. Элэгний вирусийн идэвхжил өндөр, хавдартай бүх тохиолдолд гадаад улсад элэг шилжүүлэн суулгах мэс засалд явуулдаг байсан бол одоо артер, венийн судас болон цөсний замын анатомын хэвийн бус бүтэцтэй, резус факторын үл тохиролтой, 2 донороос суулгахаас бусад тохиолдолд элэг шилжүүлэн суулгах мэс заслыг хийдэг болсон (Ж22). | | |
| 7 | ЗГҮАХ 2.1.4.1 МУТЖҮЧ-2.2.4 Орон нутагт шаардлагатай газарт яаралтай тусламжийн цэг байгуулна. | Яаралтай тусламжийн цэгийн тоо | | Орон нутагт шаардлагатай 40 цэгт яаралтай тусламжийн цэг байгуулагдсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/267 дугаар тушаалаар 20 сум, өрхийн эрүүл мэндийн төвд яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, түргэний машиныг хуваарилсан. Аймгууд сумын эрүүл мэндийн төвийг түшиглэн яаралтай тусламжийн цэгийг байгуулж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Баянхонгор, Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Өвөрхангай, Увс, Ховд аймаг, Хэнтий аймагт тус тус сумын эрүүл мэндийн төвийг түшиглэн "Хар цэг" ойролцоох нутаг дэвсгэрт Яаралтай тусламжийн цэгийн байгуулан ажиллаж байна. Дээрх сумын эрүүл мэндийн байгууллагуудад 680 гаруй иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлсэн. Яаралтай тусламжийн цэгийг байгуулснаар тусламж, үйлчилгээний үзүүлэх хугацаа багассан үр дүн гарсан. | 09 | 30% |
| 8 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11.2 Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, | Батлагдсан тушаал | | Журмыг шинэчлэн боловсруулж Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | Эрүүл мэндийн удирдлага бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан хууль дагаж гарах журмын боловсруулах 2022 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүний 40 гаруй хувь нь албан тушаал өөрчлөгдсөн, зохион байгуулах удирдлага шинэчлэгдсэнтэй холбоотой ажлын хэсгийг бүрэлдэхүүнийг баталсан тушаалыг өөрчлөх шаардлагатай болсон тул Эрүүл мэндийн яамнаас тус | 09 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журам боловсруулж батлуулна. | | | | журам үйлчлэх хүрээний байгууллагуудаас ажлын хэсэгт нэр авах 5/4731 албан бичгийг хүргүүлж, холбогдох албан тушаалтны нэрийг авч, ажлын хэсгийн тушаалыг шинэчлэн боловсруулчлаа. Холбогдох мэдрэл, нүд, чих, хамар, хоолой, сэтгэцийн мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран тээврийн хэрэгсэл жолоодоход эрүүл мэндийн талаас тавигдах шаардлагыг тодорхойлж, Жолоочийн эрүүл мэндэд үзлэг хийх журам, эрүүл мэндийн үзлэгийн хуудасны загварын төсөлд тусгаж боловсруулчлаа. Мөн тээврийн хэрэгсэлд байх анхны тусламжийн эмийн сангийн иж бүрдэл, тээврийн хэрэгсэл жолоодох үед хэрэглэхийг хориглох эм, бэлдмэлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журам, боловсруулаад байна. | | |
| 9 | ЗГҮАХ 2.1.6.8 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж, үйлчилгээг нэвтрүүлнэ. | Мобайл тусламж, үйлчилгээ нэвтэрсэн сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоо | | 140 өрхийн эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээ нэвтэрсэн байна. | Тайлант хугацаанд нийт 57 сумын эрүүл мэндийн төв, нийслэлийн 17 өрхийн эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээний багцын тоног, төхөөрөмжийг ЭМС-ын 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 246 дугаар тушаалаар хуваарилсан. 2024 оны 10-11 сард нийт 74 Мобайлын тоног төхөөрөмжүүдийг холбогдох мэргэжилтнүүдэд хүлээлгэн өгөх 3 өдрийн цогц сургалтыг нийт 12 аймаг, 4 дүүргийн 152 хүнд зохион байгуулсан. | 09 | 100% |
| 10 | ЗГҮАХ 2.1.13.3 Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, | Үнэлгээний тайлан | | Үнэлгээний тайлан гарч зөвлөмж өгсөн байна. | 1. “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” төслийг Монгол улсад 2016 оноос эхлэж, төслийн үр дүнг ЭМАШТҮ үзүүлэгч эмч нарын хүн төвтэй тусламж үйлчилгээ үзүүлэх | 09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, ил тод, нээлттэй болгоно. | | | | мэдлэг, чадвар, хандлага; мобайл технологийн ашиглалтын өнөөгийн байдал; тусламж үйлчилгээн дэх мобайл технологийн хэрэглээ ба хамралтын түвшин; VHS програмын мэдлэг, чадвар, хандлага гэсэн чиглэлээр АШУИС-ийн НЭМС-ийн дэргэдэх НЭМ-ийн хүрээлэнгийн үнэлгээний баг хийж ЭМЯ-нд танилцуулсан. Энэхүү үнэлгээнд хамрагдсан эмч нарын хүн төвтэй ЭМАШТҮ үзүүлэх мэдлэгийн дундаж түвшин 87 хувь, эерэг хандлагын түвшин дунджаар 91 хувь, дадал 83 хувь байна. Үнэлгээнд хамрагдсан ЭМАШТҮ үзүүлэгч байгууллагуудын мобайл технологи (мобайл ЭХО, ЭКГ, даралтын аппарат), түргэвчилсэн сорил (глюкоз, холестерин, гепатит В, С, тэмбүү, ХДХВ/ДОХ, хеликобактер), бусад шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг (биеийн жин, өндөр хэмжигч) тусламж үйлчилгээнд, тухайлбал урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэгт хангалттай сайн ашигладаг байна. Судалгаанд оролцогч эмч нарын 78 хувь нь мобайл технологийг ашиглах хангалттай мэдлэг, туршлагатай байна.<br>2. “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийн судалгаа” 2023-2024 онд АШУИС-ийн НЭМС-ийн дэргэдэх НЭМ-ийн хүрээлэнгийн үнэлгээний баг хийсэн.<br>ЭМАШТҮ үзүүлэгч байгууллагад хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, эмийн жор бичүүлэх, амбулаторийн тусламж үйлчилгээ, яаралтай үеийн тусламж үйлчилгээ,ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээ авахаар хамгийн их ханддаг байна.<br>ЭМТ-үүдэд хандаж буй давтамжийн хувьд нийт үйлчлүүлэгчдийн гуравны хоёр нь сард нэг удаа болон гурван сард нэг удаа үйлчлүүлдэг, байна. Сумын ЭМТ болон сум дундын эмнэлгээр үйлчлүүлэгчдийн давтамж Улаанбаатар хотын өрхийн ЭМТ-өөр үйлчлүүлэгчидтэй харьцуулахад байгаа бол<br>ЭМАШТҮ-ний талаарх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин дунд буюу 3.06 оноо (хамгийн ихдээ 5 оноо) байв. Эмэгтэй үйлчлүүлэгчид болон 60-аас дээш насны ахмадууд ЭМТ-үүдийн үзүүлж буй анхан шатны тусламж | | |

185

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээнд илүү сэтгэл ханамжтай байгааг байна гэдэг дүгнэлт тайлан гарсан. | | |
| 11 | Багийн эмчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах тухай тушаалын төсөл боловсруулна. | Батлагдсан тушаал | | Багийн эмчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах тухай тушаалыг батлуулсан байна. | ЭМС-ын 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн "Багийн эмчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах тухай" А/24 дугаар тушаал батлагдсан. | 09 | 100% |
| ХОЁР. ЭМИЙН ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 12 | ЗГҮАХ 2.1.8.4 Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлнэ. | Сүлжээнд нэгдсэн Төр, хувийн хэвшлийн лавлагаа шатлалын эмнэлгүүдийн тоо | | 200 эмнэлэг сүлжээнд нэгдсэн байна | Монгол Улсын хэмжээнд 2024 оны байдлаар нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэх ажлын хүрээнд WHONET үндэсний сүлжээнд өргөжүүлж, 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, 9 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 14 төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, 2 амаржих газар, 10 хувийн лаборатори зэрэг нийт 56 лаборатори хамрагдсан.<br>Улсын хэмжээнд нян судлалын лаборатори 65 байгаа бөгөөд үүнээс WHONET-ийн сүлжээнд 56 лаборатори тогтмол мэдээллээ өгч хэвшсэн. | 09 | 90% |
| ГУРАВ. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 13 | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/230 дугаар тушаалаар батлагдсан 2023-2024 онд хэрэгжүүлэх "Сувилахуйн тусламж, үйлчилгээний төлөвлөгөө"-ний | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | | 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | 100 хувь -15, 90 хувь -1, 20 хувь -1, Нийт 94,7 хувь байна.<br>Тайлангаас тодруулбал<br>- Тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор олгодог мөнгөн тэтгэмжид туслах сувилагчийг хамруулах эрхзүйн орчин бүрдүүлэх талаар судлаж байна.<br>- 2023 оноос БШУЯ-тай хамтран, сувилагч мэргэжлээр орон нутгийн захиалга, эрэлтийг харгалзсан бодлого хэрэгжүүлж эхэлсэн. 2023 онд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулиас Өвөрхангай аймгийн БОЭТ-ийг түшиглэн сувилагчийн 3 жилийн дипломын сургалтдаа 46 оюутан элсүүлэн сургаж байна. Элсэгчид 100% Өвөрхангай | 09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулна. | | | | аймгаас буюу сум бүрээс 1-2 оюутан суралцаж байна. Танхимийн сургалтыг аймгийн Политехникийн коллежийг түшиглэн, дадлага сургалтыг БОЭТ-д байрлан хичээллэж, багш нар АШУҮИС-ийн Сувилахуйн төв сургуулиас очиж томилогдон сургалтын чанар, үр дүнд анхааран ажиллаж байна.<br>- Орон сууцаар хангах чиглэлээр: Орон сууцны урьдчилгаа/нэг удаагийн мөнгөн тэтгэмж буюу 1,019,0 сая гаруй төгрөгийг 347 ажилтанд, түрээслээд өмчлөх эрхийг 16 ажилтанд олгон, орон сууцны ипотекийн зээлд 191 ажилтанг хамруулжээ.<br>- Эрүүл мэндийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/424 дүгээр тушаалаар Сувилахуйн албаны үлгэрчилсэн дүрмийг шинэчлэн батлуулсан.<br>- Эрүүл мэндийн сайдын 2024 оны 286 дугаар тушаалаар Эх баригчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулан хэрэгжүүлж байна.<br>- 2024 оны тайлангаар, 178 төрлийн 1172 ширхэг багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг 1817,8 сая төгрөгний санхүүжилтээр авч, хангажээ. 11 байгууллага сувилагчийн ачааллыг хөнгөвчлөх технологи нэвтрүүлэн ажиллажээ.<br>200 гаруй эх баригч, сувилагч нарыг БНСУ, БНХАУ-д богино хугацааны сургалад хамруулсан.<br>- 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Сувилагч танаараа бахархъя - 2024" арга хэмжээний "Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгаа" салбар хуралдаанаар "Сувилахуйн хүний нөөц, нийгмийн баталгааны талаар", "Сувилагчдын нийгмийн баталгаа, ажлын ачаалал", "Нийслэлийн харъяа эрүүл мэндийн байгууллагын сувилахуйн хүний нөөц", "Сувилахуйн хүний нөөцийн чиг хандлага" сэдвээр илтгэл хэлэлцүүлж, зөвлөмж гаргасан.<br>- Шинэ сувилагч, шинэ эх баригчийн төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг батлан, Орхон аймгийн БОЭТ, УХТЭ дээр хэрэгжүүлж эхлээд байна.<br>"Ерөнхий сувилахуйн түгээмэл үйлдлийн стандарт"-ын 50 төслийг Стандарт, хэмжил зүйн газарт 2024 оны 4 сард 2/1581 тоот албан бичгээр хүргүүлж, саналыг тусган ажиллаж байна. "Ахмад настанд үзүүлэх тусламж, | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | үйлчилгээний заавар"-ыг Эрүүл мэндийн сайдын 2024 оын А/22 дугаартай тушаалаар батлуулсан. | | |
| 14 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандартуудыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | Шинэчлэн батлагдсан стандартын тоо | | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шаардлагатай стандартуудыг батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын А/464 дүгээр тушаалаар үүрэг өгөгдсөн байгууллагуудад ТНБД-ын 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 2/1659 дугаар албан бичгээр стандартын боловсруулалтыг эрчимжүүлэх чиглэлийг хүргүүлсэн.<br>Эх барих, эмэгтэйчүүд судлалын 47 түгээмэл үйлдлийн стандартын төслийг 2023.12.05-ны өдрийн 5/5532 дугаар албан бичгээр хүргүүлж, 2024.09.20-ны өдөр, Ерөнхий сувилахуйн үйлдлийн 29 түгээмэл үйлдлийн стандартын төслийг 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Стандарт, хэмжилзүйн газрын цахим хуудсанд https://www.estandard.gov.mn/website/news.aspx?id=62 санал авахаар ил тод байршуулсан. Эх барих, эмэгтэйчүүдийн түгээмэл үйлдлийн стандартад санал авах хугацаа дуусаж, ирүүлсэн саналыг боловсруулан ажиллаж байна. Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны С/13 дугаар тушаалаар<br>- Биологийн идэвхт бүтээгдэхүүн. Иммунос сироп. Техникийн шаардлага MNS 6896:2024,<br>- Биологийн идэвхт бүтээгдэхүүн. "Барбад-10" 2,0г мөхлөг. Техникийн шаардлага MNS 7034:2024,<br>- Биологийн идэвхт бүтээгдэхүүн. "Шинар-8" 2,0г мөхлөг. Техникийн шаардлага MNS 7035:2024,<br>- Биологийн идэвхт бүтээгдэхүүн. Аскорбины хүчил болон цайртай шахмал. Техникийн шаардлага MNS 7036:2024,<br>- Биологийн идэвхт бүтээгдэхүүн. Аскорбины хүчил болон чацарганатай шахмал. Техникийн шаардалага MNS 7036:2024,<br>Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 12-ны С/40 дүгээр тушаалаар<br>- Эрүүл мэндийн лаборатори. Чанар, чадавхад тавих шаардлага MNS ISO 15189:2024,<br>- Үйлчлэх цэгт гүйцэтгэх шинжилгээ (ҮЦГШ). Чанарын болон чадавхын шаардлагууд MNS ISO 15189:2024 стандартууд тус тус батлагдсан. | 09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавигдах ерөнхий шаардлага; Нэг удаа хэрэглэх эмнэлгийн хэрэгсэл шалгах ба турших арга техникийн шаардлага стандартын төслүүдийг боловсруулж байна. | | |
| 15 | Эмчилгээ, оношилгооны эмнэлзүйн зааврыг боловсруулан батлуулна. | Шинээр болон шинэчлэн батлагдсан эмнэлзүйн зааврын тоо | | Шаардлагатай эмнэлзүйн зааврuудыг шинээр болон шинэчлэн батлуулсан байна | 2024.02.28-ны өдрийн А/91 дүгээр “Тууралтат халдварт өвчний эмнэлзүйн заавар батлах тухай” тушаалаар<br>1. Салхинцэцэг<br>2. Улаанбурхан<br>3. Улаанууд<br>4. Энтеровирус<br>5. Халдварт эритема<br>6. Хүний херпес вирус 6<br>7. Менингококкт<br>8. Улаан эсэргэнэ өвчний эмнэлзүйн заавар,<br>2024.04.02-ны өдрийн А/157 дугаар “Чих, хамар, хоолойн өвчний эмнэлзүйн заавар батлах тухай” тушаалаар<br>1. Нойрсох үеийн амьсгал тасалдах хам шинжийн үеийн амьсгалын дээд замын саадыг үнэлэх унтуулгатай дурангийн шинжилгээний оношилгоо,<br>2. Духны хөндийд хийгдэх ахисан түвшний хамрын дурангийн мэс засал,<br>3. Хамрын таславчийн цооролтын оношилгоо, эмчилгээ,<br>4. Хамрын доод самалдаг нөхөн сэргээх мэс засал эмчилгээний эмнэлзүйн заавар,<br>2024.04.19-ний өдрийн А/184 дүгээр тушаалаар<br>1. Гахай хавдар<br>2. Халдварт мононуклеоз<br>3. Цитомегаловирус<br>4. Халдварт саа<br>5. Сахуу<br>6. Ёлом өвчний эмнэлзүйн заавар,<br>2024.06.14-ний өдрийн А/286 дугаар тушаалаар “Хүүхдэд тохиолдох томуу, томуу төст өвчний эмнэлзүйн заавар батлах тухай”,<br>2024.07.03-ны өдрийн А/313 дугаар “Зоонозын халдварт өвчний эмнэлзүйн заавар батлах тухай” тушаалаар<br>1. Гахайн туузан хорхойтох<br>2. Үхрийн туузан хорхойтох<br>3. Балантадиз | 09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. Лямблиоз<br>5. Амёөт халдварт өвчин<br>6. Аскариоз, хүж хорхойтох<br>7. Токсоплазмоз<br>8. Лейшманиаз<br>9. Хумхаа<br>10. Энтеробиоз<br>11. Ташуур хорхойтох<br>12. Хачигт боррелиоз<br>13. Хачигт риккетсиоз<br>14. Хачигаар дамжих вируст энцефалит<br>15. Ку чичрэг<br>16. Боом<br>17. Галзуу<br>18. Бруцеллёз өвчний эмнэлзүйн заавар<br>2024.07.03-ны өдрийн А/314 дүгээр "Гэдэсний халдварт өвчний эмнэлзүйн заавар батлах тухай" тушаалаар<br>1. Цусан суулга<br>2. Сальмонеллёзын халдвар<br>3. Хоолны хордлого<br>4. Балнад, иж балнад<br>5. Кампилобактерт энтерит өвчин<br>6. Хиамдал<br>7. Урвах тахал<br>8. Ротавирусийн халдвар<br>9. Норавирусын халдварын эмнэлзүйн зааврыг тус тус батлуулсан.<br>- Зүрхний архаг ишемит өвчний эмнэлзүйн заавар,<br>- Дислипидемийн оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн үзаавар,<br>- Нугасны интрамедуляр өвчний оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн зааврын төслийг тус тус боловсруулан санал авч албажуулах шатанд явж байна. | | |
| 16 | ЭМССТ 3.3 Хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг бууруулж, чанар, | Батлагдсан төлөвлөгөө<br><br>Төлөвлөсөн арга хэмжээний | | 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжсэн | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өндөр байгаа хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг саарyулах ажлын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/331 дүгээр тушаалаар "Хавдраас сэргийлэх, хянах" хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/350 дугаар тушаалаар "Зонхилох | 09 | 90% |



190

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүртээмжийг сайжруулах төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангана. | хэрэгжилтийн хувь | | | байрлалын хавдрын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний талаарх бодлогын санал гаргах, хөтөлбөр боловсруулах" дэд ажлын хэсэг, 2024 оны А/351 дугаар тушаалаар "Ходоод, улаан хоолой, бүдүүн-шулуун гэдэсний хорт хавдар", 2024 оны А/352 дугаар тушаалаар "Уушгины хорт хавдар", 2024 оны А/353 дугаар тушаалаар "Хөхний хорт хавдар", А/354 дугаар тушаалаар "Элэгний хорт хавдар", А/355 дугаар тушаалаар "Умайн хүзүүний хорт хавдар"-ын дэд ажлын хэсгүүд тус тус байгуулагдсан. Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд нийт 14 удаа танхимаар хуралдаж, дэд ажлын хэсгүүдээс гарсан саналын дагуу хөтөлбөрийн төсөл, зонхилох байралын хавдраар 6 дэд төлөвлөгөөний төслийг боловсруулж, ЭМЯ-ны УЗХ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болсон. | | |
| 17 | ЗГҮАХ 2.1.1.4 Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулна | Батлагдсан журам | | Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг батлуулсан байна | Журмын төслийг боловсруулж, 2 удаа хэлэлцүүлж, албан бичгээр ЭМБ-аас санал авч тусган, төслийг ЭМЯ-ны удирдлагуудаас санал авч байна. | 09 | 90% |
| 18 | Донороос эс эд, эрхтэн шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | Шинэчлэн батлагдсан журам | | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А198 дугаар тушаалд нэмэлт өөрчлөлт хийсэн байна. | Донороос эс, эд, эрхтэн шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмыг боловсруулж, газар, хэлтсийн дарга нараас санал авч байна. | 09 | 90% |
| 19 | Эрүүл насжилтыг дэмжих арга хэмжээний төлөвлөгөө 2024-2027 батлуулна. | Батлагдсан төлөвлөгөө | | Төлөвлөгөө батлуулсан байна. | Эрүүл насжилтыг дэмжих арга хэмжээний (2024-2027) төлөвлөгөөний төслийг 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг төлөвлөн боловсруулсан. Тус төслийг хэлэлцүүлэх уулзалтыг 10 сарын 29-ний өдөр зохион байгуулсан. ДЭМБ-аас 12 сарын 16-20-ны хооронд ирж ажиллах зөвлөхтэй төлөвлөгөөний төсөлд санал солилцох, ДЭМБ-ын гаргасан 2023 он хүртэлх эрүүл нажмилтын төлөвлөгөөтэй уялдуулан дахин боловсруулах, энэ үеэр | 09 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ДЭМБ-аас зөвлөх ирж мэргэжил арга з[illegible]гээр хангах тул тус төлөвлөгөөний төслийг хойшлуулсан. | | |
| 20 | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулна | Шалгуур үзүүлэлт | | Шалгуур үзүүлэлт шинэчлэн гаргасан байна. | - Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлж байгаатай холбоотой "Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авахад мөрдөх шалгуур үзүүлэлтийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 2/3928 дугаар албан бичгээр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт шилжүүлэв.<br>- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ эрхлэх ажлын байранд үнэлгээ хийх хяналтын хуудас (нийтлэг шаардлага болон өвөрмөц шаардлагаар), ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх бодис худалдах болон үйлчилгээ эрхлэх, хүний эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх байгууллагын ажлын байрны үнэлгээ хийх хяналтын хуудас, хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа эрхлэх байгууллагын ажлын байрны үнэлгээ хийх хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, ЭЭХХЗГ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдээс санал авч, батлуулахад бэлэн болсон. | 09 | 70% |
| 21 | Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам болон шалгуур үзүүлэлтийг шинэчлэнэ. | Шинэчлэн батлагдсан журам | | Магадлан итгэмжлэлийн журам болон шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлуулсан байна. | - Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам"-ын шинэчлэх ажлын хүрээнд магадлан итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор "Эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийн журам"-ыг боловсруулсан. Тушаалын төслийг шинжээч, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, лавлагаа шатлалын эмнэлгийн хүрээнд 3 удаа хэлэлцүүлгийг зохион байгуулж саналыг авсан. Журмын төслийг 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Эрүүл Мэндийн Сайдад, 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр ЭМЯ-ны Удирдлагын | 09 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвлөлийн хурлаар танилцуулж, эрх зүйн орчинг дахин судалж боловсруулахаар буцаагдсан болно.<br>- Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн журмын шинэчлэлтэй холбоотой магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг шинэчлэхээр төлөвлөж ажилласан. Үүний хүрээнд:<br>o ЭМХТ-ийн Ерөнхий захирлын А/35 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулагдаж, ажлын хэсгийн уулзалтыг 3 удаа, арга зүйн сургалтыг 2 удаа зохион байгуулсан.<br>o Шалгуур үзүүлэлтийн дэд бүлгүүдийг шинжээчидтэй хамтран шүүлт хийж, эхний ээлжинд давхардсан утгатай шалгуур үзүүлэлтүүдийг хасах, нэгтгэх, өөрчлөх үйл ажиллагаа хийгдсэн.<br>o Олон улсын магадлан итгэмжлэлийн стандарттай харьцуулан шалгуур үзүүлэлтийн шинэчлэлийг хийх ажил үргэлжилж байна. | | |
| 22 | Эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хяналтын хороо, салбар хорооны ажиллах журам боловсруулж батлуулна. | Батлагдсан тушаал | | Эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хяналтын хороо, салбар хорооны ажиллах журам батлуулсан байна. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг үндэслэн Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны ажиллах дүрмийн төслийг шинэчлэн боловсруулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Монгол Улсын ёс зүйн хорооны 2024 оны 5 дугаар тогтоолтой хэрхэн уялдуулж өөрчлөх, хэн батлах эрх зүйн зохицуулалтын талаар зөвлөгөө авахаар Монгол Улсын Ёс зүйн хорооны дарга Ц.Амартөгсөд 2024 оны 2/71, 139 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Монгол Улсын ёс зүйн хорооны 2024 оны 5 дугаар тогтоолтой нийцүүлэн шинэчлэн дахин 2024-11-08-ны 139 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.<br>Аймаг, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн төвийн дэргэд ажиллах ёс зүйн салбар хороо, нэгдсэн эмнэлгийн дэргэдэх ёс зүйн хэсгийн хороодын ажиллах журмын төслийг боловсруулсан. Монгол Улсын ёс зүйн хорооноос чиглэл ирсний дараа батлуулахаар хүлээгдэж байна. | 09 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, хэсгийн хороодын гишүүдийг чадавхижуулах үндэсний зөвлөгөөн зохион байгуулах, сургалтын хөтөлбөр боловсруулна. | Зөвлөгөөний тайлан, батлагдсан хөтөлбөр | | Зөвлөгөөн зохион байгуулсан байна, хөтөлбөрийг батлуулж, hr.hdc.gov.mn-д байршуулсан байна. | • Эрүүл мэндийн салбарын ёс зүйн асуудлууд” сэдэвт онол практикийн V хурлыг 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр танхим, цахимаар хослон зохион байгуулж, 21 аймгийн ёсзүйн салбар хорооны 400 гаруй мэргэжилтнүүдэд оролцсон.<br>• Ёс зүйн хяналтын хорооноос Улаанбаатар мед эмнэлэг, Интермед эмнэлэг, зэрэг зарим төрөлжсөн мэргэшлийн хувийн эмнэлгийн ёс зүйн салбар хороог чадавхжуулахад чиглэсэн зөвлөгөө өгсөн.<br>• Ховд, Монгол-Японы эмнэлэг Архангай, Завхан, ТТАХНЭ, Төв, Говь-Алтай, Баянхонгор, аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүн баталсан тогтоол гаргасан. | 09 | 100% |
| 24 | Түрүү булчирхайн эмгэгийн оношилгоо эмчилгээний заавар батлуулна. | Шинэчлэн батлагдсан журам | | Түрүү булчирхайн эмгэгийн оношилгоо эмчилгээний зааврыг батлуулсан байна. | Түрүү булчирхайн эмгэгийн оношилгоо эмчилгээний зааврыг мэргэжлийн эмнэлгийн мэргэжилтнүүдийн багтай хамтран боловсруулж, эцэслэн Эрүүл мэндийн яамны удирдлагуудаас санал авч байна. | 09 | 30% |
| 25 | Эмнэлзүйн лабораторийн шинжилгээний лавлах хязгаар тогтоох заавар боловсруулна. | Батлагдсан тушаал | | Зааврыг батлуулсан байна. | Эмнэлзүйн лабораторийн шинжилгээний лавлах хязгаар тогтоох зааврын төслийг Монголын эрүүл мэндийн лабораторийн ажилчдын холбоотой хамтран шинээр боловсруулж байна. | 09 | 30% |
| 26 | Цусны донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн ажиллах журам боловсруулна. | Батлагдсан тушаал | | Цусны донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн ажиллах журам | Цусны донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан байгуулах сангийн ажиллах журмын төслийг Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран боловсруулсан. | 09 | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | боловсруул... . | | | |
| 27 | Эс, эд эрхтэн шилжүүлэн суулгах мэргэжлийн салбар зөвлөлийг байгуулсан байна. | Батлагдсан тушаал | | Сайдын тушаал батлагдсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/433 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэргэжлийн салбар зөвлөл” 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан. | 09 | 100% |
| 28 | Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн боловсруулна. | Батлагдсан тушаал | | Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/216 дугаар тушаалаар 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/210 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулсан. Мөн 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/433 дугаар тушаалаар Дүрс оношилгоо, Нүүр ам судлал, Мэдээгүйжүүлэх судлалын салбарын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэргэжлийн салбар зөвлөлийг шинээр байгуулж тамга, тэмдэг захиалан албажуулсан. | 09 | 100% |
| 29 | Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх “Эмнэлгийн яаралтай тусламжийн үндэсний баг”-ийг байгуулна. | Батлагдсан тушаал | | “Эмнэлгийн яаралтай тусламжийн үндэсний баг”-ийг батлуулсан байна. | Монгол Улсын Шадар сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан “Яаралтай тусламжийн үндэсний баг байгуулах” тушаалын төслийг боловсруулж, Монгол Улсын Шадар сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан “Яаралтай тусламжийн үндэсний баг байгуулах” тушаалын төслийг боловсруулсан. Яаралтай тусламжийн салбар зөвлөлөөс санал авахаар хүргүүлээд байна. | 09 | 30% |

195

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | Газар хөдлөлтийн байнгын ажиллагаатай зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана. | Тайлан хэрэгжилтийн хувь | | Төлөвлгөөний 2024 онд туссан үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлсэн байна. | Монгол Улсын Шадар сайд, Байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн даргын баталсан Газар хөдлөлтийн байнгын ажиллагаатай зөвлөлийн хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг үүрэг даавгаварын дагуу жил 2 удаа Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлдэг бөгөөд 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 2/2374 дугаар бүхий албан бичгээр болон b.kherlen@nema.gov.mn албан мэйл хаягаар хүргүүлсэн.<br>- Газар хөдлөлтийн байнгын ажиллагаатай зөвлөлийн жилийн эцсийн төлөвлөгөөнд эрүүл мэндийн салбараас 4 үйл ажиллагаа төлөвлөсөн.<br>Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд<br>• Монгол Улсын хэмжээний шарил хадгалах зориулалтын хөргөгчний тоон судалгаа<br>• Гамшиг тохиолдсоны дараах анхан шатны нийгэм, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх сайн дурын идэвхтэн, улаан загалмайн ажилтнуудыг бэлтгэх<br>• Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд газар хөдлөлт, гамшгийн үед нэрвэгсдэд эмнэлгийн яаралтай болон төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг сайжруулах<br>• Эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгсэл, цус цусан бүтээгдэхүүний нөөц, эрсдэлийн сан бүрдүүлэх, сайн дурын донорын тоог нэмэгдүүлэх<br><br>чиглэлээр салбарын хэмжээний тайлан мэдээллийг гаргаж хүргүүлсэн. | 09 | 100% |
| 31 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулах, | Батлагдсан төлөвлөгөө<br><br>Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | | 2024 оны арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. | Эрүүл мэндийн яамны дэргэдэх ХБХЭХ Дэд зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган. Дэд зөвлөлийн ээлжит 2 дугаар хурлаар үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хэлэлцэж, цаашид анхаарах асуудлыг тодорхойлсон. 2024 оны 4 дүгээр сард баталсан бөгөөд үүнээс 20 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 8 арга хэмжээ хэрэгжих шатандаа, 1 арга хэмжээ санхүү, төсвийн асуудлаас болж хэрэгжээгүй байна.<br>Дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд санхүүжилттэй холбоотой үүссэн асуудлыг | 09 | 80% |

196

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангана. | | | | шийдвэрлэх хүрээнд Дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг 2025 оны төсвийн төсөлд 1 тэрбум төгрөг байхаар санал өгсөн боловч шийдвэрлэгдээгүй. Иймд дэд зөвлөлөөс эрүүл мэндийн байгууллагуудад 2025 оны төсөвтөө Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулах төсвийг суулгах чиглэлийг өгөөд байна.<br>Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн даргын шийдвэрээр хийх ЭМЯ-ны Дэд зөвлөлийн үйл ажиллагаанд сонсголын бэлтгэл ажлыг хангаж байна. | | |
| 32 | Сувилахуйн албаны дүрэм, чиг үүргийг шинэчлэн боловсруулна. | Батлагдсан тушаал | | Сувилахуйн албаны дүрэм, чиг үүргийг батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/424 дүгээр тушаалаар батлуулсан. Тус тушаалыг Эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт 5/4434 тоот албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 09 | 100% |
| ДӨРӨВ. ЭХ, ХҮҮХДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 33 | ЗГҮАХ 2.3.2.6 Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, салбар дунд хамтын ажиллагааг бэхжүүлнэ. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | | 2024 оны төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамны хамтран баталсан “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан дараах арга хэмжээг холбогдох газартай хамтран хэрэгжүүллээ.<br>• Орон нутагт “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл байгуулах чиглэлийг т 6/5839 тоот албан бичгээр хүргүүлж, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Орхон, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгууд орон тооны бус зөвлөл байгуулан, жилийн ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах жил бүрийн гэрээнд эх, хүүхдийн эндэгдэл, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээтэй холбоотой заалтуудыг тусган оруулсан. | 09 | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Нэг хүртэлх насны хүүхдийн [illegible]рийн эргэлтийн журмыг шинэчлэн боловсруулж байна.<br>• Эх хүүхдийн мэргэшлийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний асран хамгаалагч нарт зориулсан сургалт зохион байгуулж байна.<br>• Иргэний нийгэм, олон нийт, хувийн хэвшлийг татан оролцуулах ажлын хүрээнд ЭХЭМҮТ Монголын үндэсний олимпын хороотой хамтран ажиллах гэрээ байгуулсан. Тус гэрээний хүрээнд ЭХЭМҮТ-ийн ажилчид, хэвтэн эмчлүүлж байгаа хүүхэд, тэдгээрийн асран хамгаалагчид болон ЭХЭМҮТ-өөр үйлчлүүлж байгаа нийт ард иргэдэд Олимпын боловсрол олгох, алдартай тамирчдаа алдаршуулах зорилгоор ЭХЭМҮТ-ийн нэг коридорыг Спорт-Олимпизмтой холбоотой самбар, зураг, зурагт хуудас зэргээр тохижуулж, Олимпын танхим байгуулахаар төлөвлөн ажиллаж байна<br>• Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан "Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө /2024-2025 он/"-г 2024.01.29-ний өдөр батлуулсан.<br>• Эрүүл мэндийн сайдын 2024.03.29-ний өдрийн А/147 дугаар тушаалаар "Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх хамгааллын төлөвлөгөө"-г 2024-2026 онд хэрэгжүүлэхээр батлуулан Эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.<br>• "Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон нутгийн орон тооны бус зөвлөл"-ийн гишүүдийг чадавхжуулах тус бүр 100 хүнтэй 2 удаагийн сургалтыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай хамтран зохион байгуулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Хүүхдийг эхийн сүүгээр хооллох ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх чиглэлээрх сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх зорилгоор Эхийн сүү бидний амьдралд" олон нийтэд зориулсан товхимолыг дахин хяналт, засвар хийн 10000 ширхэг хэвлүүлхээр BCI хэвлэлийн газарт эхийг шилжүүлсэн.<br>• "Хүүхдэд ээлтэй эмнэлэг санаачилга төрөх эмнэлгийн ажилтнуудад зориулсан гарын авлага" Сургагч багшийн гарын авлагын хэвлэлийн эх боловсруулсан. (Хуудас-422)<br>• 2024 онд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай" 321 дугаар тогтоол, "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний (2024-2027) онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг танилцуулах цахим сургалтыг 2024 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр 21 аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан дэс түшмэл, ЭМГ-ийн НЭМТ-ийн дарга, мэргэжилтэн нар, БШУГ-ын Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг 60 гаруй байгууллагын 180 гаруй холбогдох албан тушаалтан нарт зохион байгуулсан.<br>• Жирэмсэн эхчүүд хэрхэн дархлаагаа дэмжих вэ?, Отроор яваа жирэмсэн эхэд хэрхэн анхаарал тавих вэ?, Өөртөө хайртай хүн бүрийн заавал хэвшүүлэх дадал, Малчид, иргэдийн гэр бүлийн гишүүдэд анхааруулах зөвлөмж, цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, Сар шинийн баярын өдрүүдэд жирэмсэн эхчүүдэд зориулсан жирэмсний аюултай шинжүүд, Төрсний дараах сэтгэл гутрал, төрөх эмнэлэгт ирэхдээ бэлтгэх зүйлс, Эрүүл жирэмслэлт, Жирэмсэн эхнэртээ туслаарай 13 төрлийн инфографикийг цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээсэн. (Хандалтын тоо- 27987, хуваалцсан тоо-149) | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Зөвлөлийг ЭМЯ хариуцан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн салбарын хариуцах төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 80%-тай байна. | | |
| 34 | Эх, нярайн эндэгдлийг бүртгэх, хэлэлцэх журмыг шинэчлэн боловсруулна. | Шинэчлэн батлагдсан заавар | | Эх, нярайн эндэгдлийг бүртгэх, хэлэлцэх журмыг батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын удирдамжаар "Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг тооцох, бүртгэх хэлэлцэх журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг болон удирдамжийг баталж дараах үйл ажиллагааг зохион байгуулж, журмын төслийг боловсруулж байна.<br>• Журмын шинэчлэлийн бэлтгэл ажлын хүрээнд ДЭМБ-ын 2022 оны эхийн болон перинатал эндэгдлийн тандалт хариу арга хэмжээний удирдамжийг орчуулж, ажлын хэсэг хэлэлцэн өөрийн орны нөхцөлд тулгуурласан зохицуулалтыг тодорхойлсон.<br>• Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэл, перинатал эндэгдэлийг бүртгэх, хариу арга хэмжээ авах эмнэлзүйн аудитын хороог 5 эрүүл мэндийн байгууллагуудад байгуулсан. Энэхүү эмнэлзүйн аудитын хорооны туршлага солилцох уулзалтыг 2024.04.25-ний өдөр зохион байгуулж, "Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг тооцох, бүртгэх хэлэлцэх журам"-ыг шинэчлэлийн талаар санал авсан.<br>• Стандартчилагдсан эндэгдлийн харьцааг тооцдог PRISM-IV үнэлгээг ашиглан, "Хүүхдийн сэхээн амьдруулах тусламжийн үеийн нас барах эрсдэлийг PRISM4 ашиглан таамаглах нь" сэдэвт харьцуулсан судалгааг 2024 оны 05-р сард Эрдмийн зөвлөлөөр батлуулсан. Судалгааны ажил хийгдэж байна.<br>• Үжлээр эндсэн эхийн өвчний түүхэнд эмнэлзүйн аудит хийх ажил эхэлсэн.<br>• Улсын хэмжээнд 2022-2023 онд үжлээр эндсэн болон ноцтой хүндэрсэн эхийг 16 тохиолдолд эмнэлзүйн аудитыг НҮБХАС-гийн дэмжлэгтэйгээр ЭХЭМҮТ-д хийгдэж байна. | 09 | 30% |

| ТАВ. УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | ЭМССТ 3.4 Зонхилон тохиолдох өвчний уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээний заавар боловсруулж батлуулна. | Батлагдсан эмнэлзүйн заврын тоо | | Эмнэлзүйн 8 зааврыг батлуулсан байна. | Уламжлалт анагаах ухааны 8 заавар ("Нуугдсан халуун өвчний оношилоо, эмчилгээний заавар", "Хий цусаар дээш хөөрөх өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Саа өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Хийгээр сарнисан шар өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Бадганаар хоолой хаагдах өвчний оношилгоо, эмчилгээний заавар", "Томуу, томуу төст өвчний (дагшуур) оношилгоо, эмчилгээний заавар, Идэрчүүдийг хүчжүүлэх оношилгоо, эмчилгээний заавар, настайчуудыг шимжүүлэх оношилгоо, эмчилгээний заавар) -ын төслийг боловсруулж 5/4841 албан тоотоор Мэргэжлийн салбар зөвлөл, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, төр, хувийн хэвшлийн уламжлалт анагаах ухааны эрүүл мэндийн байгууллагаас санал авч, 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хэлэлцүүлж, эцэслэсэн. Газар хэлтсийн удирдлагуудаас санал авч байна. | 09 | 70% |
| 36 | Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх цогц арга хэмжээний (2024-2027) төлөвлөгөө боловсруулан батлуулна. | Батлагдсан төлөвлөгөө | | 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжсэн | Цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах хүрээнд: Дэд сайдаар албажсан ажлын хэсгийн үйл ажиллагааны зохион байгуулалтаар хангаж, дараах ажлыг гүйцэтгэсэн байна.<br>• Уламжлалт анагаах ухааны Нийгмийн эрүүл мэнд, Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, санхүүжилт, Хүний нөөц, Уламжлалт эмийн чанар аюулгүй байдлын нөхцөл байдлын чиглэл бүрээр нөхцөл байдлын шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэхэд хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон.<br>• "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын дагуу "Бодлогын баримт бичгийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ" хийсэн.<br>• Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулсан.<br>• Улсын Их Хурлын нийгмийн бодлогын байнгын хороонд Уламжлалт анагаах ухааны эмийн чанар аюулгүй байдлын нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг танилцуулж, Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 71 | 09 | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүгээр “Хууль батлагдсантай холбо[illegible]улан авах арга хэмжээний тухай” тогтоолыг батлуулсан.<br>Эрүүл мэндийн сайдын дэргэд Уламжлалт анагаах ухааны зөвлөл байгуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/284 дугаар тушаалаар зөвлөлийг батлуулж, төслийг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. | | |
| 37 | Уламжлалт анагаах ухааны түгээмэл үйлдлийн стандартыг боловсруулна. | Батлагдсан стандартын тоо | | Уламжлалт анагаах ухааны түгээмэл үйлдлийн 10 стандартыг батлуулсан байна. | Уламжлалт анагаах ухааны засал эмчилгээний 18 үйлдлийн стандартын төслийг боловсруулж, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагаас 5/4811 албан бичгээр санал авч, нэгтгэн хэлэлцүүлж, Стандарт хэмжил зүйн газарт батлуулахаар 5/5086 албан бичгээр хүргүүлсэн. | 09 | 90% |
| ЗУРГАА. САЛБАР ДУНДЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ХҮРЭЭНД | | | | | | | |
| 38 | Эрүүл мэндийн салбар, эрүүл мэндийн тогтолцоо, бодлого боловсруулах чиглэлээр ажлын хэсэгт орж ажиллах | Ажлын хэсгийн тоо | | Ажлын хэсэгт ажилласан байна | • Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын гишүүн<br>• Люксембургийн төслийн гишүүн, Техникийн ажлын хэсгийн дарга<br>• Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн дарга<br>• Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн гишүүн<br>• АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Үндэсний хэмжээнд түргэн тусламжийн үйлчилгээний тогтолцооны шинэчлэлийн төсөл | 09 | 100% |
| 39 | Хууль тогтоомжийн хүрээнд байгуулагдсан салбар дундын зөвлөл, комиссын | Салбар, зөвлөл, комиссын тоо | | Зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд ажилласан байна. | • Эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, стандартчиллын техникийн хорооны дарга<br>• Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажилалгааг дэмжих сангийн гишүүн | 01 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрэлдхүүнд ажиллах | | | | | | |

**ХОЁР. НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР(арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Төвлөрлийг сааруулах "үндэсний баг"-ийн үйл ажиллагааг зохион байгуулах | | | Орон нутагт үндэсний багийг ажиллах зохион байгуулалтын арга хэмжээг авсан байна. | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах, хүлээгдлийг бууруулах зорилгоор орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад үзүүлэх тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэх, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний технологийг нэвтрүүлэх, нутагшуулах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/367 тушаалаар "Зүрхний хэм судлал", "Ангиографи", "Гэмтэл, согог судлал", "Хавдар судлал"-ын үндэсний багуудыг томилж, 2024 оны 9 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн орон нутагт зохион байгуулалттайгаар багаараа ажиллаж байна.<br>Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Үндэсний багууд Хэнтий аймагт 2 удаа, Өмнөговь аймагт 2 удаа, Өвөрхангай, Орхон, Дорнод, Ховд аймагт тус бүр 1 удаа буюу нийтдээ 9 удаагийн ажлын байран дээрх сургалт, оношилгоо, эмчилгээний чиглэлээр ажиллаад байна.<br>Үндэсний багуудын Хэнтий, Өмнөговь, Өвөрхангай, Орхон, | 03-06 | 100% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | Дорнод Хэнтий, Өмнөговь, Өвөрхангай, Орхон, Дорнод аймагт ажилласан үйл ажиллагааны үр дүнгээс урьдчилсан байдлаар дурдвал, нийт 1639 хүнд амбулаторийн үзлэг хийж, үүнээс хавдрын үзлэг 601, хавдрын нээлттэй мэс засал 21, хавдрын ангиографийн мэс ажилбар 39, хими эмчилгээний үзлэг 144, хими эмчилгээ 48, зүрхний шигдээсийн ангиографийн оношилгоо эмчилгээ 64, эмчилгээ 49, мэдрэлийн судсан дотуурх оношилгоо 57, эмчилгээ 57, эмчилгээ 3, зүрхний хэм алдагдлын үзлэг оношилгоо 30 иргэнд хийсэн байна. энэ тооны иргэдийг Улаанбаатар хот руу явж, зардал чирэгдэл үүсэхээс сэргийлснээс гадна 50 гаруй иргэнд нэн шаардлагатай мэс заслын тусламжийг хугацаа алдалгүй, шуурхай үзүүлснээр амь насыг нь аварчээ.<br>Түүнчлэн Үндэсний багууд чиглэл бүрээрээ оношилгоо, эмчилгээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны сэдвээр нийт 62 удаагийн сургалтыг ажиллаж байгаа эмнэлэг болон тухайн бүсийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж зохион байгууллаа. | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | Үндэсний багийн саналд үндэслэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээний нэр төрлийн нэмэгдүүлэхэд шаардагдах хүний нөөц, тоног төхөөрөмжийн судалгаа, хөрөнгө оруулалтын төсвийн тооцоог гаргаж байна. | | |
| 2. | "Монголын эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл"-ийн үйл ажиллагаа зохицуулах | | | Төслийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангасан. | Тус төслийн багийнхантай 2024 оны 5 сараас хойш 7-14 хоногт нэг удаа уулзаж, үйл ажиллагааг чиглүүлж ажилласан: Үүнд:<br>- Сувилахуйн чиглэлээр сувилагчийн цогц чадамжид суурилсан "Сувилагч мэргэжилтний хөгжил, чадварын түвшин, түүнийг тодорхойлох жишиг аргачлал, үнэлгээний жишиг загвар"-ын төслийг 2024 оны 6 сард хянаж, эцэслэн Эрүүл мэндийн байгууллагуудад туршин, үр дүн, тайланг тайлагнах талаар Эрүүл мэндийн хөгжлийн төвд чиглэлийн хамт 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 2/2942 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- 7 сарын 24- нд ЖАЙКА ОУ-ын байгууллагын төслийн хагас жилийн тайланг хянаж, төслийн багт хүргүүлсэн.<br>- Шинэ сувилагч, эх баригчийн сургалтын хөтөлбөрийн төсөлд ЭМЯ, холбогдох мэргэжлийн салбар зөвлөлөөс авсан санал, цаашид | 03-06 | 100% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | хэрэгжүүлэх чиглэлийн хамт ЭМХТ-д хүргүүлж, төвийн захирлаар хөтөлбөрийг баталсан. Шинэ сувилагчийн сургалтыг загвар байгууллага болох Орхон аймгийн БОЭТ дээр 2025 оны 8 дугаар сарын 12-нд, УХТЭ дээр 9 дүгээр сарын 5-ны өдөр тус тус эхлүүлээд байна. 2024 оны 12 сарын 05-ны өдөр Шинэ сувилагчийн эх баригчийн хөтөлбөрийн нээлтийг хийсэн.<br>- Тус төсөл дуусахтай холбоотой тул төслийн төгсгөлийн үнэлгээг хийхээр ирсэн ЖАЙКА ОУБ-ын төв оффисын үнэлгээний багтай 2024 оны 09 сарын 16-наас 10 дугаар сарын 04-ний өдөр хүртэл хамтран ажилласан.<br>- ЖАЙКА ОУБ-ын Хүний нөөцийн хөгжлийн газрын орлогч дарга Ёшида Томоятой ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга уулзаж, төслийн үнэлгээний урьдчилсан дүнг сонссон.<br>- Ерөнхий мэргэшил судлал сургалт эрхлэх байгууллагын уулзалтыг 9 сарын 24-нд хийж, Сургалт эрхлэгч байгууллага хоорондоо туршлага солилцсон.<br>- 9 сарын 27-нд ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын даргаар ахлуулсан тус | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | төслийн техникийн ажлын хэсгийн хурлыг хуралдуулсан.<br>- энэ оны 11 сарын 08-нд болсон Хамтарсан зохицуулах зөвлөлийн хурал, "Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл" -ийн үр дүнгийн тайлангийн хурлын бэлтгэл ажлыг хангасан. ын бэлтгэл ажил, хурлын хөтөлбөр, оролцогчдын мэдээлэл, ТНБД-ын нээлтийн үг, мэндчилгээний үгийг боловсруулсан.<br>- Ерөнхий мэргэшил судлалаар сургалт эрхлэх 11 байгууллагбн холбогдох албан тушаалтантай уулзалт хийж, санал солилцсон.<br>Тус төслийн эцсийн тайланг хянаж байна. | | |
| 3 | Томуу, томуу төст өвчний эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохицуулалт нийлүүлэгчийг сонгон | | | Томуу, томуу төст өвчний эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохицуулалтыг хангаж байна. | "Томуу, томуу төст өвчний үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай" Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/435 дугаар тушаал батлуулан, хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний ор зохицуулалтаар одоо 2588 ор дэлгэн ажиллаж байна. Томуу, томуу төст өвчний эмнэлгийн тусламж, үйлчилгээний дэмжлэгт хяналтын удирдамж, хяналтын хуудсыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан. Томуу, | 03-06 | 100% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | томуу төст өвчний эмнэлгийн бэлэн байдал, нөхцөл байдлыг үзэж, ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ЭНЭҮТ, Сүхбаатар Эрүүл мэндийн төвийн харьяа Сэлбэ нэгдсэн эмнэлэг, Баянзүрх дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн харьяа Дарь эх нэгдсэн эмнэлэг,/Чулуун овоо/ Ахмад, хүүхдийн эмнэлэг, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, СХД-ийн Эрүүл мэндийн төвүүд дээр ажиллаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэсэн.<br>Томуу, томуу төст өвчний эмчилгээ, оношилгооны заавраар ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-өөс аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг,, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 670 гаруй эмч нарт сургалт зохион байгуулсан | | |
| 4 | “Лабораторийн чанарын баталгаажуулалтын тушаал”-ыг шинэчлэн батлуулах | | | “Лавлах шинжилгээ, чанарын баталгаажуулалтын лаборатори байгуулах тухай” тушаалыг шинэчлэн батлуулсан байна. | Лабораторийн шинжилгээний дотоод болон гадаад хяналтын тогтолцоог бэхжүүлэх, шинжилгээний төрлийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах зорилгоор 2007 онд Эрүүл мэндийн сайдын 299 тоот “Лавлах шинжилгээ, чанарын баталгаажуулалтын лаборатори байгуулах тухай” тушаалыг шинэчлэн боловсруулж, 2024 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн А/485 дугаар тушаалыг баталсан. | 10 | 100% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | Энэ тушаалын хүрээнд УГТЭ, ХӨСҮТ, Анагаах ухааны хүрээлэн, ЦССҮТ-ийн лабораториуд тодорхой шинжилгээний лавлагаа, чанарын баталгаажуулалт, гадаад хяналт хийж байна. Монгол Улсад шинжилгээний чанарын гадаад үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн яам, Японы Сисмекс корпорацтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээг сунгах бэлтгэл ажлын хүрээд Япон Улсын Сисмекс корпорацын Япон, Азийг хариуцсан дэд ерөнхийлөгч К.Кавахараг ЭМС-тай 2024 11 дүгээр сарын 27-нд хийсэн уулзалтыг зохион байгуулж, гэрээний хэрэгжилт, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцож, лавлагаа лабораторийн төсөл дээр хамтран ажиллах боломжийг судлан хэлэлцэхээр тохиролцсон. | | |
| 5 | Багийн эмчийн зөвлөгөөн"-ий зохион байгуулалт, багийн эмчийн онлайн судалгаа хийж, зөвлөгөөний тайланг гаргасан. | Зөвлөгөөн зохион байгуулсан байна. | | Зөвлөгөөн зохион байгуулсан байна. | "Багийн эмч нарын зөвлөгөөн"-ийг 2024 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Тус зөвлөгөөний бэлтгэл ажлын хүрээнд удирдамж, төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж батлуулсан. Багийн эмчийн нийгмийн байдал, тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлох, санал бодлогыг нь цугуулах онлайн асуумж, судалгааг | 10 | 100% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | авах бэлтгэл ажлыг хангаж, судалгааны мэдээлэлд боловсруулалт хийж, Багийн эмчийн зөвлөгөөнд танилцуулсан.<br>Мөн тус зөвлөгөөнөөр хөндөгдсөн тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэх хүрээнд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтныг нийслэлд төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээнд шуурхай хамруулах зорилгоор тусгайлсан зохицуулалтыг гарган төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болон орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад 1а/4625 албан бичгээр чиглэл хүргүүлсэн.<br>Зөвлөгөөний хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны тайлан мэдээллийг нэгтгэсэн. | | |
| 6 | Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг буруулах зорилгоор өндөр хөгжилтэй оронд эмч нарыг багаар нь сургах | | | | Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчнийг эх орондоо эмчилдэг болох зорилтын хүрээнд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх, эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх технологийг тодорхойлох, өндөр хөгжилтэй оронд эмч нарыг багаар нь сургах бэлтгэл ажлыг хангах, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг босгоход чиглэсэн дараах бодлогын арга хэмжээнүүдийг авч байна.<br>• Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/347 дугаар тушаалаар 2024 | | 100% |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | онд “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх дэвшилтэт технологийн тэргүүлэх чиглэл” -ийг баталж, тус технологийг нэвтрүүлэх төсөл, үйл ажиллагааг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан, шалгарсан 15 төслийг Шинжлэх ухаан технологийн зөвлөл хэлэлцэн дэмжин, баталгаажсан.<br>• Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам"-ын 3.1.4-д “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх үйл ажиллагаа;” -г санхүүжүүлэх эрхзүйн орчны хүрээнд өндөр хөгжилтэй оронд 13 багийг сургалтанд хамруулах, төлөвлөлтийг гарган, хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тодорхойлж, суралцах улс орон, эмнэлгүүдтэй холбоо тогтоон, сургалтын хугацаа, тов, сургалтын төлөвлөгөөг тодорхой болгох бэлтгэл ажлыг хангаад байна.<br>Төлөвлөлтийн дагуу одоогоор БНСУ, БНТУ БНЭУ, БНХАУ, Тайвань улсад эмч нар багаараа урт болон дунд хугацааны сургалтад хамрагдах арга хэмжээг зохион байгууллаа. | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | Тодруулбал,<br>- Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвийн Нярайн зүрхний хэм алдалт өвчний оношилгоо, эмчилгээний баг Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Сарвадоя эмнэлэгт 2024 оны 9 сараас 10 сарын хооронд сургалтанд хамрагдан ирээд байна.<br>- Улсын хоёрдугаар төв эмнэлгийн "Зүрхний титэм судасны хүнд хэлбэрийн нарийсал, судасны дисплазийн эмчилгээний баг БНХАУ-ын Шанхай хотын И Да эмнэлэгт 2024 оны 10 дугаар сарын 10-наас 2 сарын хугацаатай суралцаж байна.<br>- Улсын гуравдугаар төв эмнэлгийн "Тархи нугасны гүний, төвөгтэй байрлалтай, нэвчсэн, мэс заслаар авах боломжгүй болон бусад ажилбар эмчилгээ шаардагдах хавдар, хавдар төст эмгэгийн мэс засал, эмчилгээ, Тархины дурангийн мэс засал"-ын баг БНТУ-ын Чок их сургуулийн эмнэлэг, Истанбулын Америк эмнэлэг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 2 сарын хугацаатай суралцаж байна.<br>- Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Нурууны хүнд хэлбэрийн мурийлтын мэс засал эмчилгээний баг нь Бүгд Найрамдах | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | Солонгос Улсын Soonchunhyang University Bucheon hospital-д 1 жилийн турш суралцах бөгөөд сургалтын төлөвлөгөөний дагуу гишүүд зочин профессор Dr. Im Soo Bin-ны хамт 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ГССҮТ-д ирж багийн эмч нарыг эх оронд нь чадавхжуулах сургалт зохион байгуулагдана.<br>- Гэмтэл согог судлалын үндэсний төвийн "Хүүхдийн доод дээд мөчдийн төрөлхийн хүнд хэлбэрийн дутуу хөгжил, гэмтлийн мэс засал"-ын баг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Анагаахын ухааны их сургуулийн 2-р харьяа эмнэлэгт 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 1 жилийн хугацаатай сургалтанд хамрагдаж байна.<br>- Гол судасны хүнд хэлбэрийн цүлхэн, хуулралтын эмчилгээний баг БНСУ-ын Йонсэй Их сургуулийн Северанс эмнэлэгт 2024 оны 12 сараас 1 сарын хугацаатай сургалтанд хамрагдана.<br><br>Дараах багуудын сургалтанд хамрагдах бэлтгэл ажил бүрэн хангагдаад байна.<br>- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн "Аутизмын хүрээний эмгэгийн" баг БНТУ-ын | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | Трабзон Кануни эмнэлэгт 2025 оны 1 сараас 1 сарын хугацаатай;<br>- Гэмтэл согог судлалын үндэсний төвийн "Доод мөчдийн төрөлхийн хүнд хэлбэрийн согогууд, гэмтэлийн дараах шагайн үений тогтворгүйтэлийн үеийн мэс заслын эмчилгээ, доод мөчдийн дутуу хөгжил ясны хавдрын нөхөн сэргээх мэс заслын" баг БНЭУ-ын Маренго Ази эмнэлэгт 2025 оны 1 сараас 6 сарын хугацаатай;<br>- Хавдар судлалын үндэсний төвийн "Нейронавигацийн систем, нейромониторийг ашиглан тархины гүний төвөгтэй байрлалтай, гавлын суурийн хэсгийн хавдрын мэс засал эмчилгээ"-ний баг ОХУ-ын Мэдрэлийн мэс заслын холбооны төвд 2025 оны 1 дүгээр сараас 3 сарын хугацаатай;<br>- Хавдар судлалын үндэсний төвийн "Толгой хүзүүний өргөтгөсөн мэс заслын дараах согог, эрхтнийг хиймэл эрхтэн буюу протезоор орлуулах (хиймэл төвөнх), нармайн хавдрын мэс заслын эмчилгээ"-ний баг АНУ-ын NYU Langone Health Center-д 2025 оны 2 дугаар сараас 1 сарын хугацаатай;<br>- Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн "Хүүхдийн хавсарсан хөх, хүнд хэлбэрийн зүрхний төрөлхийн гажгийн үеийн | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | мэс засал"-ын баг БНХАУ-ын Фудан эмнэлэгт 2025 оны 1 дүгээр сараас 3 сарын хугацаатай сургалтанд хамрагдана. | | |
| 7 | "Ахмад настны цогц үнэлгээ", "Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх журам", "Ахмад настанд үзүүлэх цогц, тусламж, үйлчилгээний мэргэжлийн удирдлагаар хангах тухай" журмыг боловсруулах | | | | Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахтай холбоотой нэр томъёоны тодорхойлолт, тусламж, үйлчилгээний нэр төрлийн шинэ заалтууд оруулах саналыг хууль санаачлагчид хүргүүлэн УИХ-ын НББХ-ны дэд ажлын хэсэгт тус яамны төлөөлөл ажиллаж ахмад настны цогц үнэлгээ, цогц тусламж, үйлчилгээ, хувилбарт үйлчилгээний асуудлууд хуульд тусгагдсан.<br>Хууль батлагдсантай холбогдуулан ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 огны А/79 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэг батлагдан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайд хамтран батлах "Ахмад настны цогц үнэлгээ", "Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх журам", "Ахмад настанд үзүүлэх цогц, тусламж, үйлчилгээний мэргэжлийн удирдлагаар хангах тухай" журмын төслийг боловсруулж 2 сайдын хамтарсан тушаалаар батлуулахад бэлэн болсон. | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 8 | Зайн оношилгооны төв байгууулах үйл ажиллагааг зохион байгуулах | | | | Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бүтцэд Дүрс оношилгооны хариуг зайнаас бичих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх үндсэн үйл ажиллагаа бүхий Зайн оношилгооны төвийг байгуулахтай холбоотой эрхзүйн орчин бэлтгэл ажлыг хангасан. | | |
| 9 | Тусламж, үйлчилгээний дашборд хийх үйл ажиллагаанд эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаас хамтран ажиллах | | | | Эмнэлгийн тусламжийн нэгдсэн цахим ESB систем үүсгэхтэй холбоотой үйл ажиллагаанд болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний нөхцөл байдлын талаар шуурхай мэдээлэл авах зорилгоор бүрдүүлж байгаа Дашбордын өгөгдөл, хамаарлын асуудалд оролцож байна. | | |
| 10 | Томуугийн дархаажуулалтад 5 хүртэлх насны хүүхдийг шуурхай хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах | | | | Томуугийн вакцинд сургуулийн өмнөх насны хүүхдийн эрт хамруулахад чиглэсэн үйл ажиллагааг анхан шатын эрүүл мэндийн байгууллагыг түшиглэн цэцэрлэгийн шинжилгээтэй хамтатган зохион байгуулалтыг хийсэн. | | |
| 11 | Хавдрын эмийн хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах | | | | Хавдрын эмийн хүртээмжийн (АТОМ) хөтөлбөрийг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, техникийн ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг ЭМС-ын 2024.05.09-ний өдрийн А/214 дүгээр тушаалаар байгуулсан. | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | Зохицуулах зөвлөлийн 1 дүгээр хурлыг 2024.05.16-ны өдрийн 09 цагт цахимаар зохион байгуулж, МУ-д үнэлгээ хийх төлөвлөгөөг гаргасан.<br>АТОМ, МАКС хөтөлбөрийн төлөөллүүд 2024.11.25-ны өдрөөс 2024.11.29-ний өдрийн хооронд МУ-д айлчилж, ЭМС болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж, хавдрын эмийн хүртээмж, оношилгооны чадавхид хийсэн үнэлгээний төслийг танилцуулж, сайжруулсан. | | |
| 12 | Эрүүл мэндийн даатгалын тогтоолын шинэчлэл, 2025 оны эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг зохистой зарцуулахад чиглэсэн судалгаа, тусламдсан асуудлыг тодорхойлох | | | | Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих тусламж, үйлчилгээг тодорхой болгох хүрээнд даатгалын дата-д анализ хийж, эмнэлгийн шатлал бүрд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг оношийн хамааралтай бүлгээр ялаган гаргах үйл ажиллагаанд ажиллаж байна. | | |
| 13 | Ахмадын тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх ахмадын тусламжийг чанарыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах | | | | Үндсэн мэргэшлийн сургалтын Ерөнхий мэргэжлийн сургалтын хөтөлбөрт ахмад настны тусламж, үйлчилгээний сургалтын чиглэлийг нэмэхтэй холбоотой эрхзүйн болон нөхцөл байдлын судалгааг хийж ажилласан. | | |
| 14 | Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг | | | | Хавдрын тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бууруулж, төвлөрлийг сааруулахад чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд хавдрын эмгэг судлалын тусламж, | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | тодорхойлох, холбогдох арга хэмжээг зохион байгуулах | | | | үйлчилгээний чанар, хүртээмж, чадамжийг нэмэгдүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулж байна.<br>• Эмгэг судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төвийг слайд сканнераар хангаж, цахим эдийн банк үүсгэх,<br>• Слайд сканнер ашиглан өндөр хөгжилтэй орноос эмгэг судлалын зөвлөн туслах үйлчилгээ авах, зайнаас орон нутагт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх,<br>• Орон нутгийн хэмжээнд бүсийн төвүүдэд эмгэг судлалын төв байгуулах, үүнд Дорнод, Увс, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Дархан-Уул, Баянхонгор аймгийн эмгэг судлалын тусламж, үйлчилгээг сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн багцаар хангах, хүний нөөцийг чадавхжуулах | | |
| 15 | Нярайн өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилго бүхий үндэсний багуудыг байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангах | | | | Нярайн өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилго бүхий үндэсний багуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, санал зөвлөмж өгөх, удирдан чиглүүлэх ажлын хэсгийн ахалж ажиллан үндэсний багуудын уулзалт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, төлөвлөгөөний төслийг боловсруулж байна. | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 16 | Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн сурагчдад эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулах | | | | Нийслэлийн ЕБС-ийн 1-р ангийн 40164 сурагчдын 85-аас дээш хувийг буюу 34139 сурагчдыг нүд, шүд зүрхний эмгэг илрүүлэх илрүүлэг үзлэгт хамруулахаар төлөвлөснөөс 2024 оны 12-р сарын 05-ны өдрийн байдлаар нүдний үзлэгт 14017 /34.8%/ хүүхэд, шүдний үзлэгт 21249 /52.9%/ хүүхэд, зүрхний эмгэг илрүүлэх үзлэгт 17117 /42.4%/ хүүхэд хамрагдаад байна. Үүнээс амны хөндийн эмгэг оношлогдсон 77.5%, нүдний харааны өөрчлөлт оношлогдсон 22.5%, зүрхний цахилгаан бичлэгт өөрчлөлт илэрсэн 4.57% байна. Дараагийн шатны илрүүлэг оношлогоо болон эмчилгээг 2024 оны 12 сар, 2025 оны 01 сард зохион байгуулахаар төлөвлөж байна.<br>Эрүүл мэндийн болон Боловсролын сайдын 2024 оны 9/10 өдрийн А80/А384 тоот тушаал гарч 2024 онд ЕБС-ийн 1-р ангид элссэн 40164 хүүхдэд зүрх, хараа, шүдний эмгэг илрүүлэх эрт илрүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулж эхэлсэн, Нүд, шүд, зүрхний эмгэгийг эрт илрүүлэх чиглэлээр давхардсан тоогоор 1452 мэргэжилтнийг сургалтад хамруулсан байна.<br>Lepu Medical компанийн үйлдвэрлэсэн NeoECG S120 | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | загварын ухаалаг зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар Нийслэлийн 154 өрхийн эрүүл мэндийн төвийг хангасан, 2024 оны 12-р сарын 05-ны өдрийн байдлаар 17117 /42.4%/ хүүхдийг зүрхний цахилгаан бичлэг хийх шинжилгээнд хамруулаад байна. | | |
| 17 | Эмийн хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн | | | | Эмийн хуулийн хэрэгжилтийн хүрээнд үүссэн эмийн сангаар эм олгох асуудлыг газар дээр нь очиж нехцөл байдлыг нь тодорхойлох дэмжлэгт хяналтаар ажилласан | | |

**Хоёр. Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Олон улс болон Монгол Улсад шинээр гарсан хууль тогтоомж, шийдвэр, заавар, удирдамжтай тогтмол танилцах | Үйл ажиллагаанд тусгасан тайлан | - | Мэдлэг дээшилсэн байна | Ажлын чиг үүрэгт хамаарах олон улсын судалгаа, эрхзүйн орчныг судалсан. Чиг үүргийн хүрээнд шинэчлэн боловсруулагдаж байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн судлах, хууль дагаж гарах журмуудыг боловсруулсан. | 09 | 100% |
| 2. | ТАЗ, төрийн бусад байгууллага, Олон улсын байгууллагаас зохион байгуулж байгаа төрийн албан хаагчийг чадваржуулах, | Сургалтад хамрагдсан бүртгэл | - | Сургалтад хамрагдаж гэрчилгээ | Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Төрийн албаны удирдах албан тушаалтны ур | 09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэшүүлэх болон бусад цуврал вебинар сургалтад хамрагдах | | | авсан байна. | чадварыг дээшлүүлэх нь сургалтанд хамрагдан 2024 оны дугаар сарын 31-ний өдөр үнэмлэх авсан. | | |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА Р.ГАНТУЯА